



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД**

Засгийн газрын VIII байр, Олимпын гудамж 2,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: (976-51) 26 36 95, Факс: (976-11) 32 35 41
Цахим шуудан: letter@moh.gov.mn
Цахим хуудас: www.moh.gov.mn

2026.06.17 № 01/2961

сэтгэл _____ -ны № _____ -т

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.ЭРДЭНЭБАТ ТАНАА**

Таны илгээсэн 2026.05.28-ны 29 тоот албан тооттой танилцлаа. "Эмнэлгүүдийн цалингийн сан, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн талаар" 5 бүлэг асуултын хариултыг илгээв.

1 дүгээр хавсралтаар гишүүний асуултын хариу, 2 дугаар хавсралтаар Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалин нэмэгдсэнтэй холбоотойгоор эрүүл мэндийн байгууллагуудад эхний 5 сард үүссэн цалин нэмэгдэх нөлөөг хавсаргав.



Эрүүл мэндийн яам
Сайд
Э.Батшугар
2026.06.17 13:54

С.Эрдэнэбат гишүүний асуулт:

1.Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2026 оны 01 дүгээр тогтоол Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 3 дугаар сарын 24-ний өдөр бүртгэгдсэн боловч хэрэгжиж эхлэх хугацаа тодорхойгүйгээс анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилт хуучин тарифаар олгогдож, өглөг үүссэн асуудлыг хэзээ хэрхэн шийдвэрлэх шийдвэрлэх талаар:

Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдөр "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 01 дүгээр тогтоолыг баталсан ба тус тогтоолыг 2026 оны 03 дугаар сарын 24-нд Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 7566 дугаарт бүртгэн албажуулсан байна. Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлд заасны дагуу хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, бүртгэсэн өдрөөс хойш 10 өдрийн дотор "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтлүүлснээр хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлдэг.

Иймд 2026 оны ЭМДҮЗ-ийн 01 дүгээр тогтоолоор нэг иргэнээр тооцох суурь тариф өссөн тул анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудтай хийсэн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ, гэрээний тоо хэмжээг дахин шинэчлэх, тогтоолын өөрчлөлтийг тусгах ажлыг хийж байна.

Эрүүл мэндийн даатгалын сан 2025 онд 198.3 тэрбум төгрөгийн өглөгтэй гарсан бөгөөд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 18, 2026 оны 03 дугаар тогтоолуудын дагуу өглөгийг эхний 6 сард багтаан үе шаттай барагдуулахаар ажиллаж байна. 2026 оны эхний 5 дугаар сарын байдлаар лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад 13.0 тэрбум төгрөг, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад 5.5 тэрбум төгрөгийн өглөгтэй байна. Энэхүү өр төлбөрийг 6 дугаар сард бүрэн барагдуулахаар төлөвлөж байна.

2. Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлж буй аймаг, дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгүүд, төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүд нь оношийн хамааралтай бүлгээр Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэг. Гэтэл уг оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ, холбогдох журмыг зохицуулж буй Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр тогтоолыг өнөөдрийг хүртэл шинэчлэн батлаагүй байгаа шалтгаан, хэрэгжилт саатсан үндэслэл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар:

Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээг шинэчлэхээр ЭМДҮЗ-ийн 2026 оны 04 дүгээр сарын 16 болон 05 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцэж баталсан ба ХЗДХЯ руу захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр хүргүүлсэн. 2026 оны 06 дугаар сард "Жагсаалт, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 07 тоот тогтоол батлагдсан. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас 2026 оны 06 дугаар сарын 11-ний өдөр ЭМДЕГ-ын ажилтан, орон нутаг дах салбар, хэлтсийн ажилтнууд болон гэрээт 101 лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын удирдлага, эмч, мэргэжилтнүүдийг хамруулсан танхимын болон цахим сургалтыг зохион байгуулсан.

3.2022 онд эрүүл мэндийн байгууллагуудаас тусламж, үйлчилгээ худалдан авах сонгон шалгаруулалтын үр дүнгээр 3 жилийн хугацаатай гэрээ байгуулж ажилласан. Дараагийн сонгон шалгаруулалтыг явуулсан эсэх, холбогдох журамд нэмэлт, өөрчлөлт орж байгаа эсэх:

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 01/1156 дугаар албан бичгээр “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ын төсөл ирсэн бөгөөд Эрүүл мэндийн яамнаас журмын төсөлд санал боловсруулан хүргүүлэхээр ажиллаж байна. 2026 оны 06 дугаар сард багтаан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулахаар төлөвлөж байна.

4. 2026 оны эхний 5 сарын байдлаар эмнэлгүүд санхүүжилтийн эх үүсвэр талдаа цалингийн 30 хувийн өсөлт ороогүй тарифаар Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжижи, зарлага талдаа 30 хувь нэмэгдүүлсэн үндсэн цалин олгож байгаагаас ихээхэн өглөг үүссэн байна. Эмнэлгүүд эм, хоол болон бусад зардлыг гэрээт байгууллагуудад өглөг үүсгэн, байгаа төсөвтөө цалингаа тавих арга хэмжээ авч ажиллаж байгаа талаар асуудал тавьж байна. Иймд цалингийн нэмэгдлээс үүссэн зөрүү дүнг эмнэлэг тус бүрээр гарган асуудлыг хэрхэн шийдвэрлэж буй талаар:

Монгол Улсын Засгийн газраас эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалинг 2026 онд үе шаттайгаар 75 хүртэл хувь нэмэгдүүлэх бодлогын шийдвэр гаргаж 2026 оны 1 сараас 30 хувийг нэмэгдүүлэн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Энэхүү шийдвэр нь салбарын хүний нөөцийн тогтвортой байдал, үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх стратегийн ач холбогдолтой бөгөөд эмнэлгийн тусламж, үйлчилгээ дэх албан бус төлбөрийн эрсдэлийг бууруулах, эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүдийн ажлын бүтээмжийг үнэлэх, мэргэжлийн үнэлэмжийг нэмэгдүүлэх зорилттой юм.

Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын тоог Төрийн албаны цалингийн нэгдсэн системээр цалин авч буй албан хаагчдын статистик мэдээн дээр үндэслэхэд нийт 36721 албан хаагч төрийн албанаас цалинжиж /ӨЭМТ-ийн албан хаагч ороогүй тоо/ байна.

Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалин, хөлсийг нэмэгдүүлэх хүрээнд Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо хоорондын “Эрүүл мэндийн салбарын 2024-2026 оны хамтын нэмэлт хэлэлцээр”-ийг эхлүүлж 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр хэлэлцэн зөвшилцөж байгуулсан болно. Уг хэлэлцээрт үндсэн цалингийн хэмжээг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 30 хувиар, 2026 оны 8 дугаар сараас эхлэн сар бүр 9 хувиар нэмэгдүүлж, 2026 оны 12 дугаар сард 2024 оны Засгийн газрын 238 дугаар тогтоолтой харьцуулахад 75 хувиар нэмэгдүүлэхээр тусгасан.

Уг хэлэлцээрийн хүрээд Төрийн албаны тухай хуулийн дагуу төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газраас тогтоох заалтын дагуу Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар соёл, эрүүл мэнд, боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг нэмэгдүүлэх асуудлыг хэлэлцүүлэн Засгийн газрын 224, 225 дугаар тогтоолыг тус тус баталсан. Засгийн газрын 2025 оны 224 дүгээр тогтоолоор холбогдох салбарын төсвийн ерөнхийлөн захирагч нарт 2026 оны батлагдсан төсөвтөө багтаан дээрх тогтоолуудын хэрэгжилтийг хангах чиглэл өгөгдсөний дагуу Эрүүл мэндийн сайдын 2026 оны А/11 дүгээр тушаалаар эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын ТҮЭМ, ТҮ, ТҮМ зэрэглэлийн үндсэн цалинг 30 хувиар нэмэгдүүлэн баталж хэрэгжүүлсэн. Гэвч Засгийн газрын 2025 оны 225 дугаар тогтоолоор Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын хавсралтад баталсан нэмэгдэл цалинг

тооцох хувь хэмжээг өмнөх 2024 оны 238 дугаар тогтоолын дагуу хэрэгжүүлэхээр тогтоосон нь үндсэн цалингийн зөрүүтэй байдлыг бий болгож, маргааныг дагуулсан. Иймд тус асуудлыг шийдвэрлэх зорилгоор Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар нэмэгдэл "царцаасан" шийдвэрийг хүчингүй болгож, үндсэн цалинг Засгийн газрын тогтоолоор шинэчлэн батлах шийдвэр гарч 135 дугаар тогтоол батлагдсан бөгөөд 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхэлсэн.

Цалин нэмэгдүүлэх эрх зүйн баримт бичиг батлуулах үйл явц нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.14 дэх хэсгийн дагуу Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас хариуцан Төрийн албаны зөвлөлтэй хамтран Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж шийдвэрлэсэн бөгөөд УИХ-аар Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд туссан нэмэгдсэн төсөвт багтаан хэрэгжүүлэх шийдвэрийг гаргасан байна.

2026 оны 5 дугаар сарын байдлаар эрүүл мэндийн салбарын ажилчдын үндсэн цалинг 1-4 дүгээр сард 30 хувиар нэмэгдүүлж, нэмэгдэл цалинг өмнөх түвшинд "царцаан" хэрэгжүүлсэн бол 2026 оны 05 дугаар сарын 1-ээс үндсэн цалин ЗГ-ын 2026 оны 135 дугаар тогтоолын дагуу тогтоож нэмэгдэл цалинг "нэмж тогтоосон үндсэн цалин"-аас тооцож олгож эхэлсэн.

2026 оны эхний 4 сарын байдлаар нэмэгдэл цалинг ЗГ-ын 224 дүгээр тогтоолоос тооцож олгоход салбарын хэмжээнд нийт 79.1 тэрбум төгрөг нэмэгдэх нөлөө гарсан бол 5 дугаар сард шинэчлэн тогтоосон Засгийн газрын 135 дугаар тогтоолын дагуу тооцоход 27.5 тэрбум төгрөг, нийт 106.6 тэрбум төгрөгийн цалингийн өсөлтийн нөлөө гарсан.

Тус нэмэгдсэн нийт нөлөөлөл нь эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэг байгууллагуудын хувьд 101.5 тэрбум төгрөг гарсан бөгөөд эхний хагас жилийн байдлаар эрүүл мэндийн байгууллагуудын 2025 оны авлагыг барагдуулах болон гэрээ нэмж байгуулах, тусламж үйлчилгээний гэрээнээс журмын дагуу давсан гүйцэтгэлийг санхүүжүүлж зохицуулсан бол 6 дугаар сараас эхлэн тусламж, үйлчилгээний ОХБ-ийн тарифыг нэмэгдүүлсэн бөгөөд өмнөх саруудын тарифын өсөлтийн зөрүү үлдсэн 6 сарын хугацааны тарифын нэмэгдэлд шингээх, гэрээний дүнг нэмэгдүүлэх зэрэг холбогдох арга хэмжээг авч санхүүжүүлэхээр зохицуулалтыг хийж батлуулсан.

Улсын төсвөөс шууд санхүүждэг байгууллагуудын хувьд 5.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарахаар нөлөө үүссэн ба нэмэлт төсвийн эх үүсвэрийг батлагдсан төсвийн хуваарьт зохицуулалт хийх замаар шийдвэрлэн ажилласан.

5. Ахмад настанд үзүүлэх цогц, тусламж үйлчилгээний талаар:

Ахмад настанг цогц тусламж, үйлчилгээ, цогц үнэлгээнд хамруулах үйл ажиллагааг эрх зүйн хүрээнд анхан шатны эрүүл мэндийн байгууллага хариуцан гүйцэтгэдэг. Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг нэг иргэнээр тооцсон төлбөрийн хэмжээ 2026 онд ахмад настанд 61-74 насанд (гэр хороолол) 101300, (орон сууц) 90637, 75 наснаас дээш (гэр хороолол) 117295, (орон сууц) 106632 төгрөг байна.

Тэтгэврээс өөр мөнгө орлогогүй иргэд (ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн иргэд)-ийн сүүлийн 5 жилийн эрүүл мэндийн даатгалын санд төрөөс шимтгэлийг хариуцсан орлого болон эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын дүнг хүснэгтээр харуулбал: (тэрбум төгрөгөөр)

№	Он	Хүний тоо	Орлого	Зарлага
1	2021	581,623	21,195.41	228,814.90

2	2022	561,008	56,552.40	382,433.18
3	2023	538,558	86,741.5	466,055.7
4	2024	554,674	111,592.8	539,293.3
5	2025	572,152	87,531.5	480,230.5

Нийгмийн халамжийн сангаас (Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны мэдээлэл) 2025 онд идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээнд 65457 ахмад настан хамрагдан 1.2 тэрбум төгрөг, асаргааны хувилбарт үйлчилгээ буюу гэрээр асрах болон өдрөөр асрах үйлчилгээнд 2362 ахмад настан хамрагдаж 1.2 тэрбум төгрөг зарцуулсан.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/76, А/515 дугаар хамтарсан тушаалаар "Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж, үйлчилгээ үзүүлэх журам"-ыг баталсан. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2025.01.24-ний өдрийн 7087 дугаарт бүртгүүлсэн. Энэхүү журамд ГБХНХ-ын сайд, Эрүүл мэндийн сайдын 2025.11.25-ны А/219, А/441 дүгээр хамтарсан тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан ба журмын дагуу цогц үнэлгээг эрүүл мэндийн анхан шатны байгууллага болон идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээ үзүүлэх тухайн төвийн эмч хийж болно гэж заасан.

2025 онд Улаанбаатар болон орон нутгийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагын 1610 эмч, мэргэжилтэн, 2026 оны эхний 5 сарын байдлаар 581 эмч, эмнэлгийн мэргэжилтэн "Ахмад настны цогц үнэлгээ" сургалтад хамрагдсан.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/28, А/27 дугаар хамтарсан тушаалаар "Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлэхэд мэргэжлийн удирдлагаар хангах журам"-ыг баталсан.

Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад дараах тулгамдаж буй асуудлууд нийтлэг илэрч байна. Үүнд:

- Настан судлалаар мэргэшсэн эмч, сувилагч дутагдалтай
- Цогц үнэлгээг анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч нар цаасан байдлаар авч байгаа нь эмчийн ажлын бүтээмжийг бууруулдаг
- Цогц үнэлгээнд хамрагдсан боловч эргэх холбоо сул
- Ахмад настанууд цогц үнэлгээнд хамрагдсан ч идэвхтэй насжилтын үйл ажиллагаанд хамрагдах идэвх сул
- Ахмад настны идэвхтэй насжилтыг дэмжих төвүүдийн тоо хангалтгүй
- Орон нутагт идэвхтэй насжилтыг дэмжих төвүүдийн тоо хангалтгүй

Цаашид ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээ болон урт хугацааны асаргааны тогтолцоо сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ:

Эрүүл мэндийн сайдын 2026 оны 06 дугаар сарын 02-ны "Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, ажилтнуудын сахилга, хариуцлагыг сайжруулах тухай" албан даалгаварыг гаргасан. Албан даалгаварт хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмад настанд үзүүлэх тусламжийг чирэгдэлгүй болгох чиглэлээр эмнэлгийн тусламж, үйлчилгээг дараалал харгалзахгүй, түргэн шуурхай үзүүлэх орчин нөхцөл, зохион байгуулалтаар хангах, эмнэлгийн гадаад, дотоод орчны хүртээмжийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн ажилтнуудын харилцаа ёс зүйг сайжруулах талаар тусгасан.

Эрүүл мэндийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/22 тоот "Заавар батлах тухай" буюу "Ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээний заавар"-ыг баталсан.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Ахмад настны цогц үнэлгээ-(ICOPE) сургалтын гарын авлагын 2 дахь хувилбарыг монголын нөхцөлд тохируулга хийн, боловсруулах, эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийн үүргийг тодорхой заан оруулах, хяналт үнэлгээ хийх асуудлыг тус эрхзүйн баримтад шинэчлэн оруулах зайлшгүй хэрэгцээ үүссэн тул 2026 онд “Ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээний заавар ”-ыг эрүүл мэндийн сайдын тушаалаар шинэчлэн батлуулана.

Мөн Эрүүл мэндийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/366, А/191 дүгээр хамтарсан тушаалаар “Эрүүл настан, идэвхтэй насжилтыг дэмжих арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр хөндлөнгийн академик байгууллагаар “Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний хэрэгжилтэд үнэлгээ хийх нь” богино хугацааны үнэлгээг хийх,

Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэгч эмч, мэргэжилтнийг “Ахмад настны цогц үнэлгээ” сургалтад хамруулах ажлыг үргэлжлүүлэх,

Ахмад настны эрүүл мэндийг сайжруулах нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх,

Ахмад настны бүсийн чуулга уулзалтад оролцон “Ахмад настны эрүүл мэндийн талаар баримталж буй бодлого, ахмад настны цогц тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийг таниулж хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалин нэмэгдсэнтэй холбоотойгоор эрүүл мэндийн байгууллагуудад эхний 5 сард үүссэн цалин нэмэгдэх нөлөө

ДД	Байгууллагын нэр	Төрөл	Санхүүжилтийн хэлбэр	1-4 сарын нөлөө	5 дугаар сарын нөлөө	Нийт эхний 5 сарын нөлөө
1	Ар. Нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	ЭМД сангаас	736,203,148	267,408,855	1,003,612,004
2	Бө. Нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	ЭМД сангаас	899,614,790	348,137,604	1,247,752,394
3	Бу. Нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	ЭМД сангаас	591,978,024	215,213,322	807,191,346
4	Бх. Нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	ЭМД сангаас	808,223,263	294,325,143	1,102,548,406
5	Га. Нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	ЭМД сангаас	602,395,753	227,772,799	830,168,552
6	Гс. Нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	ЭМД сангаас	310,573,123	106,392,332	416,965,455
7	Да. Нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	ЭМД сангаас	1,249,561,251	444,086,953	1,693,648,204
8	Дд. Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	ЭМД сангаас	1,047,538,466	366,548,262	1,414,086,728
9	До. Зү. Нэгдсэн эмнэлэг	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	ЭМД сангаас	281,762,021	108,891,867	390,653,887
10	Др. Нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	ЭМД сангаас	672,151,127	234,171,335	906,322,461
11	Ду. Нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	ЭМД сангаас	512,139,826	179,351,607	691,491,432
12	За. Нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	ЭМД сангаас	699,885,952	246,401,201	946,287,153
13	За. От. Рашаан сувиллын төв	Уламжлалтай нэгдсэн	ЭМД сангаас	3,377,380	1,420,495	4,797,876
14	За. То. Нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	ЭМД сангаас	219,965,499	90,823,618	310,789,118
15	Ор. Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	ЭМД сангаас	1,481,875,743	547,239,084	2,029,114,827
16	Өв. Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	ЭМД сангаас	1,116,212,494	389,769,439	1,505,981,933
17	Өв. Хх. Нэгдсэн эмнэлэг	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	ЭМД сангаас	229,538,073	91,208,782	320,746,854
18	Өм. Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	ЭМД сангаас	1,012,080,787	325,355,910	1,337,436,698
19	Сү. Нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	ЭМД сангаас	601,021,021	225,252,988	826,274,009
20	Сэ. Ма. Нэгдсэн эмнэлэг	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	ЭМД сангаас	354,931,204	155,647,135	510,578,338
21	Сэ. Нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	ЭМД сангаас	685,966,515	230,041,637	916,008,152
22	Тө. Нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	ЭМД сангаас	692,918,300	250,570,604	943,488,904
23	Ув. Нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	ЭМД сангаас	920,868,670	336,487,675	1,257,356,345
24	Хо. Бу. Нэгдсэн эмнэлэг	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	ЭМД сангаас	135,300,108	60,695,943	195,996,051

Но. Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	ЭМД сангаас	1,286,806,341	440,258,993	1,727,065,334
25	Хо. Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	ЭМД сангаас	1,286,806,341	440,258,993	1,727,065,334
26	Хө. Нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	1,012,484,985	320,617,117	1,333,102,102
27	Хэ. Бе. Нэгдсэн эмнэлэг	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	176,636,653	64,202,817	240,839,469
28	Хэ. Нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	743,394,630	264,214,801	1,007,609,431
29	Хүүхдийн төв сувилал	Сувилал	197,117,289	67,625,890	264,743,179
30	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	Цус сэлбэлт			
31	Эмгэг судлалын үндэсний төв	Эмгэг судлал	130,342,271	51,010,398	181,352,670
32	Ар. Эрүүл мэндийн газар	Эрүүл мэндийн газар	116,444,585	38,641,755	155,086,340
33	Бе. Эрүүл мэндийн газар	Эрүүл мэндийн газар	42,731,639	26,910,070	69,641,709
34	Бу. Эрүүл мэндийн газар	Эрүүл мэндийн газар	55,576,916	26,970,495	82,547,411
35	Бх. Эрүүл мэндийн газар	Эрүүл мэндийн газар	51,618,177	24,745,840	76,364,017
36	Га. Эрүүл мэндийн газар	Эрүүл мэндийн газар	40,944,653	31,664,495	72,609,148
37	Гс. Эрүүл мэндийн газар	Эрүүл мэндийн газар	49,377,011	23,617,050	72,994,061
38	Да. Эрүүл мэндийн газар	Эрүүл мэндийн газар	12,250,055	12,424,171	24,674,226
39	Дд. Эрүүл мэндийн газар	Эрүүл мэндийн газар	119,822,503	63,237,603	183,060,106
40	До. Эрүүл мэндийн газар	Эрүүл мэндийн газар	60,877,345	27,604,342	88,481,687
41	Ду. Эрүүл мэндийн газар	Эрүүл мэндийн газар	15,295,097	25,393,584	40,688,682
42	За. Эрүүл мэндийн газар	Эрүүл мэндийн газар	8,395,052	22,530,392	30,925,444
43	Нийслэлийн эрүүл мэндийн газар	Эрүүл мэндийн газар	71,556,157	27,483,960	99,040,117
44	Ор. Эрүүл мэндийн газар	Эрүүл мэндийн газар	212,783,716	76,551,370	289,335,086
45	Өв. Эрүүл мэндийн газар	Эрүүл мэндийн газар	57,761,911	28,176,557	85,938,468
46	Өм. Эрүүл мэндийн газар	Эрүүл мэндийн газар	30,325,745	33,116,745	63,442,490
47	Сү. Эрүүл мэндийн газар	Эрүүл мэндийн газар	87,749,640	31,162,799	118,912,439
48	Сэ. Эрүүл мэндийн газар	Эрүүл мэндийн газар	75,905,779	28,492,676	104,398,455
49	Тө. Эрүүл мэндийн газар	Эрүүл мэндийн газар	63,711,611	22,854,291	86,565,902
50	Ув. Эрүүл мэндийн газар	Эрүүл мэндийн газар	50,314,675	28,977,622	79,292,297
51	Хо. Эрүүл мэндийн газар	Эрүүл мэндийн газар	67,078,305	28,495,022	95,573,327
52	Хө. Эрүүл мэндийн газар	Эрүүл мэндийн газар	39,443,651	24,314,625	63,758,276
53	Хэ. Эрүүл мэндийн газар	Эрүүл мэндийн газар	73,944,913	31,793,215	105,738,128
54	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	Эрүүл мэндийн газар	50,994,352	23,976,312	74,970,664
	3Г агентлаг	Улсын төсөв	131,157,007	91,202,026	222,359,033

55	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	ЗГ агентлаг	Улсын төсөв	277,030,726	190,832,606	467,863,332
56	Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн ААЛба	ЭМДҮЗ ажлын алба	Улсын төсөв	15,993,652	10,890,895	26,884,547
57	Эрүүл мэндийн хөгжлийн төв	ЗГ агентлаг	Улсын төсөв	108,867,421	69,605,450	178,472,871
58	Эрүүл мэндийн яам	ЭМЯ	Улсын төсөв	142,072,189	103,183,781	245,255,970
59	Аддиктологийн төв	Бусад	ЭМД сангаас	157,554,779	49,131,038	206,685,817
60	Нийслэлийн Амгалан амаржих газар	Амаржих	ЭМД сангаас	863,618,758	256,464,772	1,120,083,530
61	Нийслэлийн Өргөө амаржих	Амаржих	ЭМД сангаас	1,115,742,351	335,991,719	1,451,734,070
62	Нийслэлийн Түргэн тусламжийн төв	Бусад	ЭМД сангаас	1,159,168,528	334,035,144	1,493,203,672
63	Нийслэлийн Хүрээ амаржих	Амаржих	ЭМД сангаас	487,674,708	146,318,533	633,993,241
64	Нийслэлийн хүүхдийн бяцхан тэмүүлэл төв	Бусад	ЭМД сангаас	86,516,262	27,505,513	114,021,776
65	Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл урс төв	Бусад	ЭМД сангаас	72,748,679	23,593,358	96,342,037
66	Нийслэлийн Шүд эрүү нүүрний төв	Бусад	ЭМД сангаас	233,089,346	67,431,513	300,520,859
67	Уб. Бгд. Эрүүл мэндийн төв	Дүүргийн эмнэлэг	ЭМД сангаас	1,218,113,823	374,151,284	1,592,265,107
68	Уб. Бзд. Эрүүл мэндийн төв	Дүүргийн эмнэлэг	ЭМД сангаас	974,298,284	303,376,834	1,277,675,118
69	Уб. Бнд. Эрүүл мэндийн төв	Дүүргийн эмнэлэг	ЭМД сангаас	747,157,983	267,566,696	1,014,724,679
70	Уб. Бх. Эрүүл мэндийн төв	Дүүргийн эмнэлэг	ЭМД сангаас	84,435,388	27,952,116	112,387,504
71	Уб. Нд. Эрүүл мэндийн төв	Дүүргийн эмнэлэг	ЭМД сангаас	731,794,869	226,271,535	958,066,405
72	Уб. Сбд. Нэгдсэн эмнэлэг	Дүүргийн эмнэлэг	ЭМД сангаас	768,412,367	221,381,862	989,794,228
73	Уб. Сбд. Эрүүл мэндийн төв	Дүүргийн эмнэлэг	ЭМД сангаас	629,533,636	204,290,876	833,824,513
74	Уб. Схд. Нэгдсэн эмнэлэг	Дүүргийн эмнэлэг	ЭМД сангаас	1,568,849,793	526,796,418	2,095,646,210
75	Уб. Схд. Эрүүл мэндийн төв	Дүүргийн эмнэлэг	ЭМД сангаас	918,700,594	288,300,448	1,207,001,042
76	Уб. Худ. Нийслэлийн хүүхдийн сувилал	Дүүргийн эмнэлэг	ЭМД сангаас	106,661,478	32,484,195	139,145,673
77	Уб. Худ. Нэгдсэн эмнэлэг	Дүүргийн эмнэлэг	ЭМД сангаас	907,955,495	266,686,745	1,174,642,240
78	Уб. Худ. Эрүүл мэндийн төв	Дүүргийн эмнэлэг	ЭМД сангаас	617,081,421	180,535,463	797,616,883
79	Уб. Чд. Эрүүл мэндийн төв	Дүүргийн эмнэлэг	ЭМД сангаас	1,040,513,789	301,266,029	1,341,779,818
80	Уб. Бзд. Энэрэл эмнэлэг	Дүүргийн эмнэлэг	ЭМД сангаас	246,765,562	74,887,717	321,653,280
81	Ар. Зоонозын өвчин судлалын төв	Зооноз	Улсын төсөв	33,492,941	15,218,524	48,711,465
82	Бө. Зоонозын өвчин судлалын төв	Зооноз	Улсын төсөв	33,678,247	19,444,852	53,123,099

83	Бх. Зоонозын өвчин судлалын төв	Зооноз	Улсын төсөв	19,797,776	22,412,310	42,210,086
84	Га. Зоонозын өвчин судлалын төв	Зооноз	Улсын төсөв	26,648,849	15,798,306	42,447,155
85	Ду. Зоонозын өвчин судлалын төв	Зооноз	Улсын төсөв	13,671,403	6,464,502	20,135,905
86	За. Зоонозын өвчин судлалын төв	Зооноз	Улсын төсөв	27,496,299	12,470,092	39,966,391
87	УБ. Зооноз өвчин судлалын үндэсний төв	Зооноз	Улсын төсөв	186,454,860	71,258,681	257,713,541
88	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв	НЭМУТ	Улсын төсөв	223,502,571	71,946,531	295,449,103
89	Нийслэлийн зооноз өвчин судлалын төв	Зооноз	Улсын төсөв	28,051,787	14,994,606	43,046,393
90	Өв. Зоонозын өвчин судлалын төв	Зооноз	Улсын төсөв	22,260,062	12,137,624	34,397,686
91	Өм. Зоонозын өвчин судлалын төв	Зооноз	Улсын төсөв	29,208,341	12,147,637	41,355,978
92	Сэ. Зоонозын өвчин судлалын төв	Зооноз	Улсын төсөв	29,113,782	11,874,667	40,988,450
93	Ув. Зоонозын өвчин судлалын төв	Зооноз	Улсын төсөв	27,780,412	18,552,301	46,332,713
94	Хо. Зоонозын өвчин судлалын төв	Зооноз	Улсын төсөв	22,360,335	19,625,981	41,986,315
95	Хө. Зоонозын өвчин судлалын төв	Зооноз	Улсын төсөв	30,796,178	16,316,580	47,112,758
96	Хэ. Зоонозын өвчин судлалын төв	Зооноз	Улсын төсөв	31,195,636	18,852,049	50,047,685
97	Арьсны өвчин судлалын үндэсний төв	Төрөлжсөн	ЭМД сангаас	343,210,044	110,117,878	453,327,921
98	Геронтологийн үндэсний төв	Төрөлжсөн	Улсын төсөв	108,164,488	39,920,224	148,084,711
99	Гэмтэл, согог судлалын үндэсний төв	Төрөлжсөн	ЭМД сангаас	2,847,293,684	862,631,650	3,709,925,334
100	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	Төрөлжсөн	ЭМД сангаас	1,157,223,170	359,717,857	1,516,941,027
101	Улсын гуравдугаар төв эмнэлэг	Төрөлжсөн	ЭМД сангаас	2,168,925,275	639,495,688	2,808,420,963
102	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Төрөлжсөн	ЭМД сангаас	2,099,639,781	683,234,355	2,782,874,136
103	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	Төрөлжсөн	ЭМД сангаас	1,732,594,594	525,576,283	2,258,170,878
104	Хавдарт өвчин судлалын үндэсний төв	Төрөлжсөн	ЭМД сангаас	1,294,630,153	451,677,315	1,746,307,468
105	Халдварт өвчин судлалын үндэсний төв	Төрөлжсөн	ЭМД сангаас	2,053,240,922	658,011,759	2,711,252,681
106	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	Төрөлжсөн	ЭМД сангаас	2,793,452,976	858,340,100	3,651,793,076
107	Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёр	Төрөлжсөн	ЭМД сангаас	1,523,269,280	419,750,424	1,943,019,704
108	Га. Уламжлалт анагаах ухааны төв	Уламжлалт	ЭМД сангаас	51,084,280	15,730,063	66,814,344
109	Дд. Уламжлалт	Уламжлалт	ЭМД сангаас	49,929,894	16,640,931	66,570,825

110	До. Уламжлалт	Уламжлалт	ЭМД сангаас	49,319,855	20,092,081	69,411,935
111	Ду. Уламжлалт	Уламжлалт	ЭМД сангаас	46,232,234	14,529,490	60,761,724
112	За. Уламжлалт	Уламжлалт	ЭМД сангаас	49,810,730	17,423,390	67,234,120
113	Сү. Уламжлалт	Уламжлалт	ЭМД сангаас	37,600,456	12,659,781	50,260,237
114	Хэ. Уламжлалт	Уламжлалт	ЭМД сангаас	59,974,483	23,578,482	83,552,966
115	Сум, тосгон, ӨЭМТ-ийн нөлөө Цалин нэмэгдсэн нөлөө 1-5 сар	анхан шатны эмнэлэг	ЭМД сангаас	23,606,776,139	8,752,705,263	32,359,481,402
				79,137,159,000	27,503,762,423	106,640,921,424